

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэх
ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий
Үндэсний зөвлөлийн хуралдааны тэмдэглэл**

Үндэсний зөвлөлийн хуралдаан 2012 оны 5 дугаар сарын 8-ны өдөр (Мягмар гариг)-ийн 16.00 цагт Төрийн ордны Нутгийн удирдлагын танхимд болов.

Үндэсний зөвлөлийн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд, Үндэсний зөвлөлийн дарга С.Батболд, үндэсний зөвлөлийн гишүүн Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, Үндэсний зөвлөлийн орлогч дарга Д.Зоригт, Үндэсний статистикийн хорооны дарга С.Мэндсайхан, Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний Зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Долгор, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Д.Дамба, Нээлттэй нийгэм форумын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал, Нээлттэй нийгэм форумын менежер Н.Дорждарь, Монголын ажил олгогч эздийн холбооны ерөнхийлөгч Л.Нямсамбуу, Хүний эрх, хөгжил төвийн тэргүүн Г.Уранцоож, Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, үндэсний зөвлөлийн гишүүнийг төлөөлж Эрдэнэт Үйлдвэр ХХК-ийн төлөөлөгчийн газрын ерөнхий менежер И.Идэш, Авилгатай тэмцэх газрын соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Д.Дуламсүрэн, Үндэсний аудитын газрын санхүүгийн хяналтын хэлтсийн дарга Ч.Батбаяр, Оюу толгой ХХК-ийн Олон талт хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Х.Лхамаа нар оролцов.

Үндэсний зөвлөлийн хуралдаанд Ашигт малтмалын газрын дарга Алтансүх, Засгийн газрын ахлах референт Э.Сумьяа, Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга С.Мягмардаш, Татварын ерөнхий газрын Улсын төсвийн орлого хяналтын газрын эрдэс баялгийн татварын хэлтсийн байцаагч Энхтуяа, Ашигт малтмалын газрын мэргэжилтэн С.Мөнхсайхан, Улаанбаатар Аудит корпорацийн ахлах аудитор Н.Эрдэнэцог, Б.Мэндбаяр ОҮИТБС-ын ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, Санхүүгийн мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, Харилцаа, мэдээллийн мэргэжилтэн С.Батбаяр нар урилгаар оролцов.

Үндэсний зөвлөлийн хуралдааныг Монгол Улсын Ерөнхий сайд, Үндэсний зөвлөлийн дарга С.Батболд нээж, мэндчилгээ дэвшүүлж, үг хэлэв.

ОҮИТБС чухал санаачлага бөгөөд нийгмийн хувьд ч тэр, хэмжээгээрээ ч, агуулгын хувьд ч үр дүнтэй байх ёстой гэж үзэж байна.

Анх олон улсын түвшинд тухайн үеийн Их Британий Ерөнхий сайд байсан Тони Блейрийн санаачлагаар гаргаж байсан энэ асуудлыг Монгол Улс дэмжин нэгдэж, Монгол Улсын өөрийн хөгжлийн онцлог, Олборлох үйлдвэрлэлийн санаачлагын олон улсын байгууллагаас тавигдаж байгаа шаардлага, энэ бүх зүйлд бид нийцүүлж ажиллах ёстой гэсэн зарчмаар хандаж ирсэн. Ямар ч байсан ажил явж байгаа, зарим нэг үр дүн гарч байна. Энэ санаачлагыг хэрэгжүүлэхэд зөвхөн төр захиргааны байгууллага биш тал бүрийн оролцоо тэр дотроо гурван талын оролцоо бүхий удирдлага чухал байгаа юм. Иргэний нийгэм, бизнесийн байгууллага, Засгийн газар гэсэн хамтын ажиллагаа, оролцоог хангасан хяналт тавих үүрэг бүхий Үндэсний зөвлөлийг ажиллуулж байна. Үүний үр дүнд тодорхой алхам гарч байна гэж үзэж байна. Наад зах нь хамтраад хуралддаг хэлбэр, үйл ажиллагааны зарчмууд нь гарсан байна.

Засгийн газар олборлох үйлдвэрлэл эрхэлдэг компаниас хүлээж авсан татвар, төлбөрийн тайлангаа, компаниуд нь улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөрийн тайлангаа бие даан хараат бусаар тус тус тайлагнадаг, хөндлөнгийн аудитийн консорциум энэ хоёр тайланд тулгалт хийж зөрүү гарах юм бол тодруулга хийж авах ийм боломж нөхцөл бүрдэж байна. Энэ тайлангаар гарч байгаа тоо хэмжээ нь нэмэгдэж байгаа. Тайлант оролцогч талууд ашиглаж сурх, иргэд сонирхогч талуудад ойлгомжтой байдлаар хүргэх, тогтмол мэдээлэх талаар анхаарах ёстой. Тайланд нэгдэж байгаа компаниудын тоо жил болгон нэмэгдэж байна. 2006 онд анх энэ санаачлага хэрэгжиж эхлэхэд 25 компани нэгдсэн тайланд хамрагдаж байсан бол одоо 150 компани оржээ. Хоёрдахь гол зүйл бол тайлангаар гарч байгаа зөрүү жилээс жилд багасч байна. Жишээ нь: 2006 оны тайланийн зөрүү 25 тэрбум төгрөг байсан бол 2010 онд 11 сая төгрөг болж буурсан байна. Олборлох үйлдвэрлэлд оруулж байгаа хөрөнгө оруулалт маш их нэмэгдэж байгаа хэдий ч зөрүү багасч байгаа нь дэвшилттэй алхам болж байна гэж үзэж байна. 2012 оны тайланд 200 орчим компанийг хамруулна гэсэн зорилттой байна.

Цаашид Үндэсний зөвлөлөөс баталсан ОУИТБС-ын дунд хугацааны буюу 2014 он хүртэлх стратегийг тууштай хэрэгжүүлэх, үүнийг олон нийтэд мэдээлэх, мөн ил тод байдлын санаачлагын өнөөдрийн хүрсэн түвшинг бууруулахгүй байх тал дээр анхаарч ажиллах ёстой. Мөн энэ Санаачлагыг өргөжүүлэх чиглэлээр Олон улсын Удирдах хорооноос дэвшүүлж байгаа бодлогууд байна. Үүнийг Үндэсний зөвлөл, үндэсний бодлоготойгоо нийцүүлж хэрэгжүүлэх ёстой. Олон улсын болон манай улсад ОУИТБС-ыг хэрэгжүүлж байгаа ажлын зэрэгцээ анхаарах ёстой зүйлүүд байна.

Энэ салбар дээр анхаарч хийх ёстой хууль эрх зүйн зохицуулалт шаардаж байгаа, бодитоор ил тод болгох ёстой татвар, ялангуяа уул уурхайн салбарт лицензийн наймаа гээд иргэдийн дунд яригдаг асуудал байна, байгаль орчин, орон нутаг, нийгэм эдийн засгийн хувьд гарцаагүй анхаарах, шаардлагатай бол таслан зогсоох асуудал байж байна. Ил тод байдлын асуудлыг ярихаар энэ асуудлыг тойроод байж болохгүй гэж бодож байна. Хайгуулын ажлыг зохих шаардлагын дагуу хийгээгүй атал зөвхөн лицензийн наймаа хийдэг энэ асуудлыг хэлж байгаа юм. Бид энэ Санаачлагын хүрээнд ч тэр, нөгөө талаасаа манай Үндэсний зөвлөлийн хүрээнд ч, Засгийн газрын түвшинд ч хэд хэдэн зүйлийг ялангуяа энэ салбарын хувьд анхаарч авч хэрэгжүүлэх ёстой гэж бодож байна.

Нэгдүгээрт, лицензний наймаатай холбоотойгоор сул чөлөөтэй лицензгүй байгаа орон нутгийн тусгай хэрэгцээнд байгаа бүх газрыг Засгийн газар нөөцөндөө авах хэрэгтэй. Засгийн газар бүх газраа нөөцөндөө авъя. Тэгж байж цаашдаа зөвхөн тодорхой хэдэн түшмэлүүдийн гараар биш, Улсын Их Хурлын шийдвэрээр тухайн оны батлагдсан үндсэн чиглэлийн дагуу газрыг нөөцөөс гаргаж байх тийм зарчим руу шилжих нь зүйтэй гэсэн чиглэл өгч байна. Цаашид нөөцөд авсан талбай дээр төсвийн хөрөнгөөр эрэл судалгааны ажил хийж, уг судалгааны дүнгээ үндэслээд гагцхүү туршлагатай, санхүүгийн чадвартай, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах тийм аж ахуйн нэгжүүд дээр түшиглэж ажиллах ёстой. Лицензийн наймаа, сул газруудыг нөөцөнд авах, төр засгаас тавих хяналт энэ дээр Үндэсний зөвлөлөөс тавих хяналтыг нээлттэй болгож байгаа нь чухал ач холбогдолтой гэж бодож байна.

Ашигт малталаын газрын шинээр томилогдсон Алтансүх даргад зориуд үүрэг өгье. Ашигт малтмалын газарт шинээр томилогдсон удирдлагууд, дээр дурдсан агуулга, зарчимд нийцүүлэн бүтцийн өөрчлөлт хийх хэрэгтэй. Зохих мэргэжлийн шалгалт авч

шинээр хүмүүсээ бүрдүүлэх ёстай. Ёс зүйтэй, хууль эрх зүй, мөн салбарын хүрээнд мэдлэгтэй, чадвартай хүмүүсийг тавих ёстай. Ашигт малтмалын газрыг тойрсон авлига, хээл хахуулийн асуудал байнга яригдаж байдаг. Үүнээс салах ёстай. Үнийг цэвэрлэх үндсэн арга бол ёс зүйтэй, мэдлэгтэй, мэргэжлийн хуулийн хүмүүсийг сонгон шалгаруулж ажиллуулах ёстай.

Бидний хувьд байнга яриад байгаа, хэрэгжилт нь удаашралтай байгаа Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бус, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль байж байна. Энэ нь Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаатай шууд холбоотой биш хэдий ч гэсэн тойруу замаараа бол холбоотой асуудал. Гол усны эх бүрэлдэх газар, ой модны сав газар ашигт малтмал олборлохыг хориглох тухай асуудлыг Засгийн газар ойрын хугацаанд хуралдаанаараа авч хэлэлцэж, яригдаж байгаа тодорхой хэмжээний лицензүүдийн хувьд цуцлах хүртэл шаардлагатай арга хэмжээг авах ёстай гэж үзэж байна.

Стратегийн ач холбогдолтой ордуудын талаарх хуулийн асуудал байна. Ер нь энэ асуудал нэлээн яригдаж байгаа. Орд, газруудын стратегийн жагсаалтад нэмэлт оруулах асуудлыг УИХ-д оруулж шийдэх ёстай. Шаардлагатай бол энэ зөвлөлөөс, турван талын бусад механизмуудаар ярьж тодорхой шийдвэрийг гаргах ёстай.

Монгол Улсын уул уурхайн салбар, олборлох үйлдвэрлэлийн асуудал хөгжлийн ач холбогдолтой давуу талуудыг бий болгож байгаагийн зэрэгцээ шинэ сорилтуудыг бас бидэнд тулгаж байна. Тийм учраас Үндэсний зөвлөлийн хүрээнд салбарын үйл ажиллагааг нээлттэй ил тод болгох, оролцоог хангах, хяналт тавих иргэний нийгмээс, мөн бүх оролцогч талуудаас энэ ажил дээр ирэх жилүүдэд нэлээн бодитой үр дүн гаргах ёстай. Үүнд Үндэсний зөвлөл, харьяалагддаг байгууллагууд, гишүүдийн үүрэг оролцоо улам нэмэгдэх ёстай. Тэр чиглэлээр гишүүдийн үүрэг хариуцлага, оролцоо, хамтын ажиллагааг цаашдаа анхааръя.

Тодорхой саналтай хүмүүс байвал саналаа хуваалцахыг хүсье.

Б.Долгор: Санал бодлоо хэлэх, асууж тодруулах зүйл байвал хэлнэ үү

Н.Дорждарь: Олон улсын удирдах хороонд би иргэний нийгмийг төлөөлж оролцож байна. Хэрэгжүүлж байгаа улс орнуудын Засгийн газрыг төлөөлж Зоригт сайд гишүүнээр ажилладаг. Олон улсын Удирдах хорооны гишүүд жилд 2-3 удаа уулзаж шийдвэрүүдээ гаргадаг. Хэрэгжүүлж байгаа улс орнуудад хурал зохион байгуулах сонирхол өндөр байдаг. Удирдах хорооны хурлыг Монголд хийх бололцоотой юу гэдгийг албан бусаар асууж байсан. Энэ асуудлыг танд уламжилъя. Олон улсын Удирдах хороог саяхнаас Английн Хөгжлийн яамны сайд байсан хүн удирдаж байгаа.

Олон улсад энэ Санаачлагыг цаашид яах вэ, чанаржуулах ямар асуудлууд байна гэдгийг хэлэлцэж, дүрмээ шинэчилсэн юм. Дараа жилээс дүрмийг бас шинэчлэн өөрчлөх талаар ярьж байна. Энэ дээр ялангуяа өнөөдөр та энэ лицензийн асуудлыг хөндөж ярилаа. Үүн дээр олон жил энэ чиглэлээр ярьж ирсэн. Олон улсад ч гэсэн энэ асуудлаар арай илүү өрнөж байгаа мэтгэлцээн бол Засгийн газар, аж ахуйн нэгж, хувийн салбартай байгуулж байгаа гэрээнүүдийг ил тод байлгах асуудал байгаа юм. Ялангуяа Монгол Улсын хувьд бол Оюу толгойтой байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээ ил болсон байгаа. Бусад, жишээ нь газрын тосны бүтэээгдхүүн хуваах гэрээний асуудал, дээрээс нь өмнө нь Эрдэнэт, Монголросцветмет болон Засгийн газар хооронд

шинээр хүмүүсээ бүрдүүлэх ёстай. Ёс зүйтэй, хууль эрх зүй, мөн салбарын хүрээнд мэдлэгтэй, чадвартай хүмүүсийг тавих ёстай. Ашигт малтмалын газрыг тойрсон авлига, хээл хахуулийн асуудал байнга яригдаж байдаг. Үүнээс салах ёстай. Үнийг цэвэрлэх үндсэн арга бол ёс зүйтэй, мэдлэгтэй, мэргэжлийн хуулийн хүмүүсийг сонгон шалгаруулж ажиллуулах ёстай.

Бидний хувьд байнга яриад байгаа, хэрэгжилт нь удаашралтай байгаа Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бус, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль байж байна. Энэ нь Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаатай шууд холбоотой биш хэдий ч гэсэн тойруу замаараа бол холбоотой асуудал. Гол усны эх бүрэлдэх газар, ой модны сав газар ашигт малтмал олборлохыг хориглох тухай асуудлыг Засгийн газар ойрын хугацаанд хуралдаанаараа авч хэлэлцэж, яригдаж байгаа тодорхой хэмжээний лицензүүдийн хувьд цуцлах хүртэл шаардлагатай арга хэмжээг авах ёстай гэж үзэж байна.

Стратегийн ач холбогдолтой ордуудын талаарх хуулийн асуудал байна. Ер нь энэ асуудал нэлээн яригдаж байгаа. Орд, газруудын стратегийн жагсаалтад нэмэлт оруулах асуудлыг УИХ-д оруулж шийдэх ёстай. Шаардлагатай бол энэ зөвлөлөөс, турван талын бусад механизмуудаар ярьж тодорхой шийдвэрийг гаргах ёстай.

Монгол Улсын уул уурхайн салбар, олборлох үйлдвэрлэлийн асуудал хөгжлийн ач холбогдолтой давуу талуудыг бий болгож байгаагийн зэрэгцээ шинэ сорилтуудыг бас бидэнд тулгаж байна. Тийм учраас Үндэсний зөвлөлийн хүрээнд салбарын үйл ажиллагааг нээлттэй ил тод болгох, оролцоог хангах, хяналт тавих иргэний нийгмээс, мөн бүх оролцогч талуудаас энэ ажил дээр ирэх жилүүдэд нэлээн бодитой үр дүн гаргах ёстай. Үүнд Үндэсний зөвлөл, харьяалагддаг байгууллагууд, гишүүдийн үүрэг оролцоо улам нэмэгдэх ёстай. Тэр чиглэлээр гишүүдийн үүрэг хариуцлага, оролцоо, хамтын ажиллагааг цаашдаа анхааръя.

Тодорхой саналтай хүмүүс байвал саналаа хуваалцахыг хүсье.

Б.Долгор: Санал бодлоо хэлэх, асууж тодруулах зүйл байвал хэлнэ үү

Н.Дорждарь: Олон улсын удирдах хороонд би иргэний нийгмийг төлөөлж оролцож байна. Хэрэгжүүлж байгаа улс орнуудын Засгийн газрыг төлөөлж Зоригт сайд гишүүнээр ажилладаг. Олон улсын Удирдах хорооны гишүүд жилд 2-3 удаа уулзаж шийдвэрүүдээ гаргадаг. Хэрэгжүүлж байгаа улс орнуудад хурал зохион байгуулах сонирхол өндөр байдаг. Удирдах хорооны хурлыг Монголд хийх бололцоотой юу гэдгийг албан бусаар асууж байсан. Энэ асуудлыг танд уламжилъя. Олон улсын Удирдах хороог саяхнаас Английн Хөгжлийн яамны сайд байсан хүн удирдаж байгаа.

Олон улсад энэ Санаачлагыг цаашид яах вэ, чанаржуулах ямар асуудлууд байна гэдгийг хэлэлцэж, дүрмээ шинэчилсэн юм. Дараа жилээс дүрмийг бас шинэчлэн өөрчлөх талаар ярьж байна. Энэ дээр ялангуяа өнөөдөр та энэ лицензийн асуудлыг хөндөж ярилаа. Үүн дээр олон жил энэ чиглэлээр ярьж ирсэн. Олон улсад ч гэсэн энэ асуудлаар арай илүү өрнөж байгаа мэтгэлцээн бол Засгийн газар, аж ахуйн нэгж, хувийн салбартай байгуулж байгаа гэрээнүүдийг ил тод байлгах асуудал байгаа юм. Ялангуяа Монгол Улсын хувьд бол Оюу толгойтой байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээ ил болсон байгаа. Бусад, жишээ нь газрын тосны бүтэээгдхүүн хуваах гэрээний асуудал, дээрээс нь өмнө нь Эрдэнэт, Монголросцветмет болон Засгийн газар хооронд

байгуулсан гэрээнүүд байна. Эдгээр гэрээнүүдийг ил тод болгох асуудал ОҮИТБС-ын дунд хугацааны стратегийн баримт бичигт ч орсон. Олон улсад ч гэсэн энэ хандлагаар мэтгэлцэж байгаа, мэдээж энэ дээр нууцлах зүйл гардаг юм шиг байгаа юм. Гэхдээ ерөнхийдөө хөрөнгө оруулалтын гэрээ, жишээ нь Оюу толгойн гэрээг ил болголоо гээд муу болсон зүйл байхгүй байна. Энэ зарчмаа баримтлаад дээрээс нь баялгийн эзэд болох иргэд гэдэг утгаараа баялгаа хэрхэн зарцуулж байгааг мэдэх эрхтэй гэдэг үндсэн зарчмаараа гэрээг ил тод байлгах тал дээр Үндэсний зөвлөлөөрөө ярьж хэлэлцэж шийдвэрлэвэл зохимжтой байна.

П.Эрдэнэжаргал: ОҮИТБС-ын тайлангаа гаргах үйл явц нааштай ахиц өөрчлөлт гарч байгааг хэлэхэд таатай байна. Ерөнхий сайд сая хэллээ “Оролцож байгаа компаниудын тоо нэмэгдэж байна” гэж, хоёрдугаарт тайлангийн чанар сайжирч байгаа тал харагдаж байна. Цаг хугацааны хувьд ч гэсэн 2010 оны тайланг 2011 ондоо багтаагаад гаргачихлаа. Энд нэг анхаарах зүйл байна тайлангаас харахад. Уул уурхайн компаниудаас орон нутагт өгч байгаа хандив, тусlamж үнэн зөв бодитой гарч чадахгүй байгаа нь энэ тайлан дээрээс харагдаж байна. Нээлттэй нийгэм форумын санхүүжилтээр Өмнөгөөвь аймгийн Ханбогд, Цогтцэций суманд ОҮИТБС-ын тайланг бүрнээр нь гаргасан, нэгдсэн тайлантай аудит хамт хийлгэсэн. Үндэсний хэмжээнд гаргасан тайлан, орон нутагт гаргасан тайлан хоёрыг харьцуулаад үзэхэд орон нутагт өгсөн хандив дээр их том зөрүү гарч ирж байна. Жишээлбэл, Энержи-ресурс компани Цогтцэций суманд энэ Үндэсний тайланд 10 сая төгрөг өгсөн гэж байна. Гэтэл манай хавсралт болгож аудитаар хянасан тайлангаар 418 сая төгрөг болсон байна. Айвенхоу майнз дээр Ханбогд суманд арай бага байгаа юм. 40 сая төгрөгийн зөрүү гарч ирж байх жишээтэй. Цаашдаа анхаарах зүйл бол орон нутагт өгч байгаа хандив дэмжлэгийг арай илүү нарийвчилж үзэх боломж бий юу тэсэн санал хэлье.

Г.Уранцоож: Ганцхан асуудлыг хэлье. Энэ тайлан их ач холбогдолтой, уул уурхайн компаниуд байгаль орчны нөхөн сэргээх зардлын 50 хувийг урьдчилан тусгай дансанд байршуулна гэсэн заалт байгаа. Тайлангаас харахад тэр үүргээ биелүүлдэггүй юм байна. Маш олон компаниуд зардлаа байршуулдаггүй юм байна. Хоёрдугаарт, тэр байршуулсан зардал дээр авсан, аваагүй гэсэн зөрүү их гарч байна. Нийтдээ аваад үзэхэд 900 сая төгрөг л байршуулсан байна. Тэгэхлээр байгаль орчны нөхөн сэргээлт дээр хичнээн төгрөг зarah ёстай билээ. Үүнтэй холбогдуулаад байгаль орчныг сэргээх, хамгаалах асуудал дээр дансны үйл ажиллагаа, нөхөн сэргээлтийн зардлыг тооцох асуудал дээр нэлээн анхаарал тавих хэрэгтэй байна. Энэ асуудлыг анхааралдаа авч үзнэ үү.

С.Мэндсайхан: Монгол Улс энэ жил НҮБ-ын статистикийн комиссын гишүүн болсон. Анхны чуулган дээр Монгол улс байгалийн нөөцөд суурилсан эдийн засаг гэсэн ийм сэдвээр санаачлага гаргасан. Энэ юу вэ гэхлээр статистикийн байгууллагууд тодорхой нэг сэдвээр тэр чиглэлийн статистикийг яаж багцаар нь боловсронгуй болгох вэ гэдгийг боловсруулаад олон улсад зөвлөмж болгож хэрэгжүүлдэг ийм зүйл байгаа юм. Бидний санаачилсан зүйлийг Монгол шиг тухайн орны эдийн засгийн хөгжлийг байгалийн баялаг, газрын тос гэх мэт тодорхойлдог дэлхийн 20-иод орон НҮБ-ын чуулган дээр дэмжсэн.

Бид байгалийн нөөцөө өхлээд ерөнхийд нь үнэлэх, байгалийн нөөцөөсөө ашиглаж байгаа зүйлээ зөв бүртгэх, тэр нөөцийг ашигласнаар эдийн засагт орж байгаа ашиг, тэр нь юу юунд зарцуулагдаж байна вэ, байгаль орчинд үзүүлж байгаа хор нөлөө ямар гэх зэргээр ерөөсөө л байгалийн нөөцийн ашиглалттай холбоотой бүхий л зүйлийг

цогцоор статистикаар илэрхийлэх арга зүй боловсруулах зорилготой. Хороо 4-5 жилийн хугацаанд байгуулагдаж 2 жил тутамд НҮБ-ын статистикийн комисст тайлангаа тавина. Энэ ажлыг Австралийн статистикийн товчоо, Монголын Үндэсний Статистикийн хороо санаачилж дэмжигдсэн. ОХУ, Канад, АНУ, Норвеги, Швед, булангийн орнууд гээд 15 орон шууд оролцохоо мэдэгдээд байгаа. 8 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулах хурал болно. Албан ёсоор Засгийн газарт Таны нэр дээр албан бичиг ирүүлж байгаа. Энэ ажлыг анхнаас нь зохион байгуулахад Монгол Улсын Засгийн газар, Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам манайд гаргаж байгаа үзүүлэлтээс аль аль нь болж байна, аль нь дутагдаад байна гэх мэтээр энэ бүхнийг тодорхойлж өгөх юм бол Олон улсын статистикийн байгууллагууд яг энэ бүх зүйлийг цогцоор нь тодорхойлоход хэрэг болох бол уу гэж бодож байна.

Өнгөрсөн 2-3 жилийн хугацаанд энэ Үндэсний зөвлөлд ажиллаад гарч байгаа тайланг харахад жил ирэх тусам ахиц дэвшил гарч, зөрүүнүүд багасч байна. Гэхдээ 2010 оны тайлангийн дүнгээс харахад тодорхой хэмжээний зөрүү гараад тэрийг нь нэлээн нэмэлт ажил, зохицуулалт, тодруулга хийж байж зөрүү бага гарч байгаа ийм зүйл байна. Ер нь яваандаа байнгын статистик, бүртгэл тооцоооны зүйлийг тодорхой болгочих юм бол тайлан гаргахад ч амархан, аудит хийхэд ч тэнд ийм нэмэлт ажил хийх нь багасах байхаа гэж бодож байна. Тийм учраас Засгийн газрын зүгээс энд дэмжиж өгөөчээ гэсэн ийм хүсэлт тавьж байна.

Л.Нямсамбуу: Ганцхан асуудал байна. Яам агентлагынхан уул уурхайн компаниудаас хандив аваад байдгийг болимоор байна. Хараад байхад сонирхлын 100 хувийн зөрчилтэй. Жишээ нь Ашигт малтмалын газар, эсхүл Эрдэс баялаг, эрчим хүчний яам өөрсдөө 10, 15 сая төгрөгийн хандив авсан байх юм. Энэ чинь бүх юмыг муухай бий болгож байгаа. Тийм учраас Засгийн газар шийдвэр гаргаад доорх хүмүүстээ хатуу анхааруулаад хандив авахыг болиулчих хэрэгтэй байна.

Д.Дамба: Ой, усны хагалбар газар ашигт малтмал олборлох, хайгуул хийхийг хориглох тухай хууль гараад, түүнийг хэрэгжүүлэх тухай Ерөнхий сайд үүрэг өгч байна. Нэгэнт Монгол Улсын хууль гарсан юм бол түүнийг хэрэгжүүлэх ёстой байх. Гэхдээ үүн дээр цаана нь 200 гаруй аж ахуйн нэгж ажлын объектгүй болж, түүнийг дагаад 15,000 гаруй хүн ажилгүй болж байна. Энэ асуудлыг нэг талаас нь харж бodoхгүй бол ганцхан талаас нь асуудлыг хараад байвал болохгүй, боломжгүй юм шиг байна. Надад нэг ийм санал байна. Компаниудын үйл ажиллагааг нь зогсоогоод энэ жилээс эхлээд нөхөн төлбөрийг нь өгөөд явуулж байна. Үүнийг шийдээд явуулахад амар байна. Компаниуд нэгэнт хууль гарсан болохоор хэрэгжүүлээд явна. Энэ дээр үлдэж байгаа нөөцийг яах вэ гэдэг асуудал маш их сэтгэл зовоож байна. Хуулийн гол үндсэн үзэл баримтлал нь ой, ус, гол мөрнөө хамгаалах асуудал. Гэтэл үүнийг цааш нь үргэлжлүүлээд гар аргаар ашигт малтмал олборлодог нөгөө бидний “Нинжа” гэж нэрлэдэг ард түмэн энэ рүү ороод явчихна. Юун хамгаалах биш улам сүйтгэх ийм байдал яг одоо бэлэн байгаа. Энийг яаж зохицуулья гэж бодож байгаа юм бол? Үүн дээр маш хэцүү сэтгэгдэл төрөөд байна. Зүй нь энэ нөөцийг тодорхой хэмжээгээр тэр компаниудад өндөр шаардлага тавьж байгаад байгаль орчинд нь халгүй ээлтэй технологиор тэр үйл ажиллагааг нь явуулаад нөөцийг нь дуусгуулах ёстой гэж би боддог юм. Нэгэнт ийм хууль гараад зогсоож байгаа учраас энэ асуудал их хэцүү байна.

Өөр зүйл бол энэ компаниудыг ажилтай болгох талаар Засгийн газраас юм хийгээч гэж хүсмээр байна. Тухайлбал Өмнийн.gov дээр зам барих шийдвэр Засгийн

газар гаргасан. 700-аад км зам эхний ээлжинд тавья гэж шийдэж байх шиг байна. Тэрний суурь газар шорооны ажилд энэ компаниудыг эхний ээлжинд давуу эрхтэйгээр оролцуулж тэр ажлыг хийлгэж болдоггүй юм уу. Яагаад гэвэл тэр компаниуд өөрсдөө газар шорооны ажил хийдэг техник технологитой, мэргэжлийн хүнтэй ийм байгууллагууд. Тийм маягаар ажлын байрыг шийдэж болох байх. Тэнд очиж ажиллах нь ажиллана биз, ажиллахгүй нэг нь бол тэдний өөрсдийн асуудал. Ямар ч байсан ийм бололцоо боломжийг олгож өгөөч гэж хүсмээр байна.

Уул уурхайгаас орж байгаа орлогыг ард түмэнд 21.000 юм уу, эсхүл сая төгрөгөөр ч юм уу тарааж байсанд орвол, уул уурхайгаас орсон орлогоос ажлын байр бий болгох, шинээр мэргэжил мэдлэг олгох, сая миний ярьсан сэтгэл зовоогоод байгаа гар аргаар ашигт малтмал олборлогч нарыг сургаж дадлагажуулж уул уурхайн мэргэжил олгож, барилгын мэргэжил олгож, ажлын байртай болгож өгөх талаар арга хэмжээ авах нь арай дээр юм уу. Тэгэхгүйгээр цэрэг цагдаагаар хаагаад хориод дийлдэхгүй гэдэг нь тодорхой. Байгаль сүйднэ, хүний амь сүйднэ, эрүүл мэнд хохирно, их олон сөрөг үр дагавар байгаа учраас энэ сургалт үйлдвэрлэлийн төвүүд дээр эдгээр улсуудыг зориуд үнэ төлбөргүйгээр сургаад зардлыг нь уул уурхайгаас олж байгаа орлогоос гаргаад ажлын байраар хангаж өгвөл энэ улсууд заавал амь насаа золиослоод нүх ухаад яваад байх сонирхол байхгүй. Энэ талаас нь харж үзэж явбал яасан юм бэ гэсэн нэг санаа байна.

Стратегийн орд газруудын асуудал их яригдаж байна. Жаахан гайгүй ажиллаад, гайгүй төсөл хэрэгжүүлээд, хайгуулыг өөрсдөө зардлаараа хийгээд нөөцийг нь тогтоогоод ашигт малтмалыг ашиглах болоод эхлэхээр стратегийн орд болгоод хувийн өмчийг заавал тодорхой хувийг төрд авна гээд дайрдаг нь зөв юм уу, буруу юм уу. Монгол Улсын Үндсэн хуулинд хувийн хөрөнгийг хуулиар хамгаалах тухай заалт байгаа. Тодорхой хэмжээгээр тэр стратегийн нэр томьёогоо бодож боловсруулмаар байна. Ашиг малтмалын хуулийг шинээр боловсруулаад явж байгаа, одоогоор хараахан энэ парламент хэлэлцэж амжихгүй дуусах юм шиг байна. Тэгэхээр энийг цэгцэрч энэ стратегийн гэх асуудал нэр томьёо нэг мөр болтол энэ асуудлаа түр хүлээвэл яасан юм бэ.

Н.Баярсайхан: ОҮИБС-ыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх нь маш чухал байна. Үндэсний зөвлөл хуралдаад ажлын хэсэг идэвхитэй ажиллаад явж байна. Орон нутгийн түвшинд энэ Санаачлагыг хэрэгжүүлэх механизм нь ажиллаж чадахгүй байгаа. Засгийн газрын 80 дугаар тогтоол тодорхой хугацаанд цаасан дээр байсан. Ажил хэрэг ерөөсөө явагдаагүй. Аймгуудын Засаг даргын орлогч нараар ахлуулсан Зөвлөлүүд байсан, гэхдээ ямарч ажил хийгдээгүй. Орон нутгийн түвшинд хэрэгжих механизмыг яаж ажиллуулах вэ энэ дээр та санаа тавьж ажиллаасай гэж хүсч байна.

Засгийн газрын байгууллагууд хандив, тусlamжийг маш ихээр авч байгаа. Зөвхөн АМГ, ЭБЭХЯ ойн баярын арга хэмжээнд 60 сая хүртэл төгрөг авсан байна. Сумын Засаг даргын түвшинд, Аймгийн Засаг даргын түвшинд авч байна. Энэ хүмүүс тус Санаачлагыг хэрэгжүүлэх, уул уурхайн компаниудад хуулийн хэрэгжилтэд шаардлага тавьж байх ёстой хүмүүс, хандив тусlamж аваад ирэхээр эргээд шаардлага тавих боломжгүй болчихож байна. Ийм болохоор Санаачлага маань ч явахгүй байна. Уул уурхайн үйлдвэрлэл хариуцлагатай явж чадахгүй байна. АМГ эргээд өөрсдөө шаардлага тавьж чадахгүй ийм түвшинд хүрээд байна. Тэгэхээр Санаачлагыг хэрэгжүүлэхэд орон нутгийн түвшинд механизмыг ажиллуулахад нэлээн анхаарал тавиачээ.

Бас нэг зүйл бол Засгийн газрын гадаадын ажиллах хүчний орлогыг маягтаар тайлагнадаг. Оюу толгой компани дээр Монгол ажилгүй хүмүүсийг бүртгэж аваад картанд нь 300,000 төгрөгийг сар болгон хийдэг. Энэ бол тодорхой баримт. Би саяхан Өмнөговь аймгийн 2 суманд очсон. Тэгэхэд юу хийж байна гэхэд “Зүүд биш байгаа даа” гэдэг ажил хийдэг гэж байгаа. Энэ юу вэ гэхээр сар тутам Оюу толгой компаниас 300,000 төгрөг шилждэг. Гадаадын ажиллах хүчинээс илүү олон монголчуудыг ажиллуулж байгаа болох гэж байгаа юм. Гадаадын ажиллах хүчний татвараас зугтаж ийм юм хийж байгаа тодорхой нэртэй устай асуудал. Энэ дээр яж хяналт тавих, хяналтын тогтолцоог бий болгох вэ гэдэг асуудал байна. Үүн дээр анхаарал хандуулах хэрэгтэй байна.

Хандив, тусlamж гээд байгаа. Сумын түвшний хоёр тайланг гаргахад Оюу толгойгоос хуучин мод, хуучин хөнжил, хашааны мод зэргийг хандив гэсэн байна. Сумын айлуудын сургачдын сургалтын төлбөрийг төлсөн байна. Үнийг бас хандив тусlamж гэж бүртгэсэн байна. Засгийн газраас юуг хандив, тусlamж гэж үзэхийн бэ гэдэг зүйлийг гаргаж ирэхгүй бол сумын түвшинд. Сангийн сайдын бас нэг тушаал байгаа, хандив тусlamжийг бүртгэх журам гээд. Энэ журмын хэрэгжилт нь 2009 оны тайлан дээр бас хангалтгүй хэрэгжилттэй байна гэсэн. 2010 онд бас хангалтгүй хэрэгжилттэй байна гэсэн байсан. Засгийн газрын 80 дугаар тогтоол шиг ийм хангалтгүй зүйлийг Санаачлагын түвшинд хэрэгжүүлэх гээд гаргаад байдаг. Араас нь хэрэгжилтэнд нь санаа тавьдаггүй болохоор үр дүнгүй болоод байна.

Д.Дуламсүрэн: Хандивын асуудлыг тодорхойлоогүй учраас янз бүрийн хяналтгүй байдал үүсч байна гэж үзэж байна. Одоо бол үүнийг хянах механизмыг төр засгаас бүрдүүлээд өгсөн. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль 5 дугаар сарын 1-нээс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Энэ хуульд хандив гэж юу юм бэ гэдгийг тодорхой заагаад өгсөн, төрийн бүх байгууллага, нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, нийтийн албан тушаалтнууд нийтийн хэрэгцээнд аливаа бэлэг, туслалцааг авахгүй гээд заасан, юу ч авахгүй, авсан тохиолдол бол цөөхөн, өөрөөр хэлбэл ямар нэг байдлаар албан үүрэгтэйгээ харьцаа байхгүй, холбоогүй гуравдагч этгээдээс тодорхой нэг сургалт болон үйл ажиллагааны зохион байгуулалт техникийн дэмжлэгтэй холбоотой санхүүгийн туслалцаа буюу хандивыг авч болно. Зүгээр авахгүй, заавал дээд шатны байгууллагын зөвшөөрөл, эсхүл эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр ийм л үйл ажиллагаанд хандивыг авч болохоор зохицуулалт ороод ирсэн. Бид нар хандив авчихаасай, энэ маягтын дагуу энийгээ бэглөөд ороод ирээсэй, бариад авъя гэдэг үүднээс биш урьдчилан сэргийлж нийт төрийн байгууллага, албан тушаалтан, нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагад болохгүй юм байна гэдгийг ойлгуулах чиглэлээр саяын яригдаад байгаа Засгийн газраас гаргасан журам, өөр бусад зүйлүүд энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулж тодорхой ажлууд явах нь гарцаагүй. Дараагийн удаа хандив тусlamжийн асуудлыг энд яагаад зөрүү байгаа юм бэ гэж 2011 оныг ярихгүй, 2012 оны 5 дугаар сарын 1-нээс хууль үйлчилж эхлэсэн учраас, энэ нь бол өөр түвшинд хянгдаад явах боломжтой болсон учраас харин өөр чиглэлээр энэ ажлыг үр дүнтэй, өөрөөр хэлбэл ямар нэг зөрчилд оруулахгүйн тулд юу хийх вэ гэдэг чиглэлээр Засгийн газрын зүгээс хууль хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг авч болох болсон. Ой тэмдэглэх ч юмуу өөр бусад хандив зэрэг зүйлийг авч болохоргүй зохицуулалтай болсон.

С.Батболд: Манай зарим гишүүд тодорхой асуудлаар ярьж байна. Уг нь зөв, гэхдээ та бүгдийн хувьд ч тэр, засгийн ажил дээр ч, өнөөдрийн Засгийн газрын тэргүүний үүргийг гүйцэтгэж байгаа энэ үед тэр болгон бид нар уулзаад энэ салбарын асуудлыг бүхэлд нь тэр дотроо тодорхой асуудлаар ярих завшаан олдож өгдөггүй учраас тодорхой цаг хугацааг та бүгд маань ерөнхий асуудлуудад зарцуулаад, байр сууриа хэлэлцэж байгаа асуудал болон энэ салбарын ерөнхий асуудлуудаар хэлж байгаа нь надад болон ялангуяа Засгийн газарт та бүгдээс бодитой мэдээллийг авч, асуудлыг хариуцаж байгаа, мөн сэтгэлээсээ бодитой оролцоогоороо хийж байгаа энэ хүмүүсийн үг бол ач холбогдолтой гэж үзэж байна. Энэ утгаараа ажил хэрэгч ярилцлага боллоо гэж тэмдэглэн хэлье.

Цаашдаа бидний яриа, асуудлууд дараа дараагийн хурлууд дээр зарим нь тодорхой болж хэлэлцэгдэх асуудлууд болох байх. Зарим нь Засгийн түвшинд энэ тэмдэглэлдээ тусгаад цаашид анхаарах энэ дээр ярьж байгаа зүйл маань оролцогч гурван тал тэр дотроо Засгийн газрын үйл ажиллагаанд бодлого тодорхойлох, шийдвэр гаргах түвшинд зөвлөмж болгох анхаарал тавих ийм асуудлууд болно гэж ойлгож байна. Тэр агуулгаар нь та нар хэллээ. Бүгд ямар нэг хэлбэрээр тусгалаа олох ёстой, зохицуулалтууд нь хийгдэх ёстой ийм асуудлуудыг хөндлөө гэж бодож байна.

Олон улсын удирдах хорооны хурлыг Монголд хийх нь зүйтэй. Манайх бол уул уурхайн салбараар олон улс, дэлхий нийтийн сонирхлыг татсан, мөн зарим нэг байдлаар сайн талаараа ч татаж байгаа, зарим нэг асуудлаар ч гэсэн бүхэлдээ байгаль орчин, авлига, хээл хахууль, хүнд суртал зэрэг олон асуудлаар сөрөг анхаарал татаж байгаа учраас бид энэ дээр гарч байгаа нөхцөл байдлаа ярих, яг энэ шиг олон улсын түвшинд сайн туршлагыг сонсох, өөрсдийгөө гаргаж ирэхэд хэрэгтэй байх гэж бодож байна. Хугацаа нь хэзээ байх юм, Үндэсний зөвлөлийн гишүүний хувьд бичгээр Үндэсний зөвлөлийн хуралдааны тэмдэглэл дээр тусгаад хийвэл Засгийн газар дараа нь аваад ажил болгоход хэрэгтэй болох байх.

Уул уурхайн салбарт хийгдэж байгаа гэрээнүүдийг ил болгоё, нээлттэй болгоод тавьчихад болохгүй юм байхгүй байхаа гэснийг би зөв зүйтэй асуудал гэж бодож байна. Үүнийг харин зохицуулалтыг нь яаж үзэх ёстой юм, одоо мөрдөгдөж байгаа хууль дүрмээр нь, шинээр хийх зохицуулалтууд яаж орох ёстой юм, газрын тос бусад уул уурхайн хөрөнгө оруулалтын гэрээнүүдийг Алтансүх дарга бодож үзэх ёстой. Энэ дээр санал боловсруулж ярилцъя, шаардлагатай бол үүнийг журам зохицуулалт болгож хууль эрх зүйн зарим зүйлд өөрчлөлт оруулах хэрэгтэй гэж бодож байна.

Хандивын асуудлыг нэлээн олон хүн ярилаа. Үүн дээр нэг шийдвэр гаргачихъя. Засгийн газар энэ тал дээр тодорхой болгоод төрийн байгууллагууд бүхэлдээ хандивын арга хэмжээг төсвийн санхүүжилттэй байгууллагууд хандив аваад байх нь зохижгүй, одоо болтол бидний байгаа нүүр царай. Одоо төсөв санхүү боломжийн хэмжээнд байгаа, ямар ч байсан манай өнөөдрийн түвшинд төрийн байгууллагуудын төсвийн зардал, цалинг боломжоор нь нэмж байгаа. Цаашлах тусам энэ ажил хийгдээд явна. Хөдөлмөрийн үнэлэмж, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлэх хүрээнд үүнийг бүр тодорхой нэг талд нь шийдвэр гаргаад хандивыг авахгүй болгох хэрэгтэй. Хоёрын хооронд авна гэвэл нүх гаргаад л хуулийн цоорхой гаргаад л яаж ийж байгаад нэг юм зөвшөөрөл олгоод авна. Өөрсдийн төсвөөрөө юмаа хийж сурдаг соёл руу орох нь ардчиллын өөрийн соёл болно. Баруунд бидний яриад байгаа Англид Тони Блейрийн санаачлагад яам нь компаниудаас татвар аваад, хандив

авдаг ийм зүйл байхгүй байх. Нэгэнт төлөвшил, хөгжил рүү явж байгаа юм чинь энийгээ шийдээд гаргаад тавьчих нь зүйтэй. Дахиад энэ хурлынхаа тэмдэглэлд оруулчихъя.

Хууль хэрэгжихгүй асуудал, ялангуяа байгаль орчинтой холбоотой асуудлыг ярьж байна. Орон нутгийн хөгжилд нийгмийн хариуцлага, мөн нийгмийн салбарт хандив өгдөг, сургууль соёл зэрэгт ямар нэгэн байдлаар хандив өгдөг, байгаль орчин сэргээхэд орон нутагт хандив өгөөд байна, орон нутгийн нийгмийн хариуцлагын хүрээнд. Ийм зорилготой хандив, төрийн байгууллагын ажилтны таашаал, ямбыг хангах хандив хоёрын хооронд ялгаатай. Тийм учраас энэ хандив зориулалтын хувьд ямар агуулгаар, хуулийн зохицуулалтын хувьд ямар агуулгаар байх юм гэдгийг ялгаж салгах шаардлага байгаа болов уу. Энийг харин ил тод болгох асуудал. Нийгмийн хариуцлагын хүрээнд хийж байгаа ажлыг ил тод болгох асуудлыг тусад нь зохицуулалт орж таарах байх гэж бодож байна.

Байгаль орчинтой холбоотой асуудал, хууль хэрэгжихгүй, урьдчилан нөхөн сэргээх зарчмыг хэрэгжүүлэхгүй, 50 хувийн урьдчилгаа хийхгүй гэдэг асуудал цаашдаа хууль нь байдаг, хэрэгждэггүй байдаг тал дээр анхаарах ёстой, манай мэргэжлийн байгууллагууд энд сууж байгаа учраас энэ дээр дүгнэлт хийх нь зүйтэй гэж үзэж байна.

Сая Мэндсайхан даргын хэлсэн арга хэмжээ нь дахиад олон улсын чанартай мөртлөө, манайд ач холбогдолтой арга хэмжээ байна. Засгийн газар энийг дэмжих нь зүйтэй. Бид үүнийг дэмжье, яамдуудыг оролцуулаад шаардлагатай шийдвэр гаргуулах юм уу, танилцуулга хийх шаардлагатай гээд эртхэнээс оруулах нь зүйтэй.

Уул уурхайн ассоциацийн нөхдүүдийн ярьж байгаа зүйлд бид байгаль орчноо хамгаалах асуудал, мөн уул уурхайн баялгаа зөв зохистой ашиглах асуудал, хууль хэрэгжүүлэхдээ бүр хэт туйлшрал болгочихгүй байх асуудал, гаргаж буй хуулиндаа цааш нь нухацтай боловсруулж гаргах асуудал, мэдээж хэрэг эмоцидаа хөтлөгдөхөөс гадна зарчимдаа хөтлөгдөх гээд олон санаа байнаа. Энэ маань эдийн засаг, нийгмийн үндэслэлийг гаргаж байх гэсэн санааг цааш цаашдаа бodoх ёстой юм. Хариуцлагатай уул уурхай хөгжүүлэх, зөв ашиглалт бий болгох гээд. Байгаль орчныг хамгаалах асуудлаа нэгд нь тавья. Тэгээд тэрнийгээ дагуулаад эдийн засгаа авч үзэе. Өмнө нь байгаль орчин 2 дугаарт яваад, эдийн засаг нь урд нь явдаг байсан. Одоо сүүлийн үед байгаль орчноо эдийн засагтай зэрэг явъя гэсэн асуудал тавьж байгаа бол, ер нь цаашдаа байгаль орчноо урд нь тавья. Тэгээд тэр бодлогодоо зохицсон ашигт малтмалаа зөв ашиглах төрийн бодлого, бодлогод зохицсон технологийн болон эдийн засаг, ашиглалтын чиглэлийн шийдлүүдийг дэмжиж байх бодлого руу орох нь зүйтэй. Хүн болгон, улс болгон ярьж байгаа ногоон хөгжил байгаль орчин нь зөвхөн моодны яриа болчих төдий биш яг бодитой ажил болгохын тулд бодлого нь яаж зохицуулалт хийгдэх вэ гэдэг дээр манай оролцогч талууд, Үндэсний зөвлөлийн гишүүд, оролцогч байгууллагуудын хүрээнд тодорхой санал, санаачлага, бодитой шийдлүүдийг хэлж гаргах байх гэж бодож байна.

Бусад хүмүүсийн ярьсан зүйлүүдийн хувьд бүхэлдээ боломжийн санал санаачлагууд гарсан байна. Бидний ажил бол үүнийгээ хэрэгжүүлэх, тодорхой асуудлууд дээр тодорхой шийдвэрүүд гаргаад түүний гүйцэтгэлийн хяналтыг тавьдаг, хэрэгжилтийг шаарддаг, хэрэгжилт зөвхөн Засгийн газар дээр буухаас гадна Үндэсний зөвлөл, иргэний нийгэм, бизнесийн оролцоо, мөн хэрэгжилтийн явцад хяналт тавьдаг зарчмыг цаашид яаж бодитой ажил болгох вэ, хамтын хариуцлага, хамтын ажил болгох вэ гэдэг дээр тодорхой санаачлагууд гаргах нь зүйтэй. Яагаад гэвэл Засгийн газар

баахан үүрэг аваад үлдчихдэг, хууль дээр буусан зарим зүйлд хүч нь хүрдэггүй, нөгөө талаасаа сэтгэл нь ч дутдаг, мэдлэг чадвар нь хүрдэггүй тал олон зүйл дээр байгаа.

Тийм учраас энийг бид нийгэмтэйгээ, бизнес эрхлэгчтэйгээ, үйлдвэрлэгч настай иргэний нийгмийн төлөөлөх хяналт, Засгийн газар гэсэн гурван талын үйл ажиллагаагаа цаашид улам боловсронгуй болгох, энэ дээр тохирсон эрх үүргийн хуваарилалт, хяналт оролцооны хуваарилалтыг цааш нь яаж боловсронгуй болгох вэ гэдэг дээр бид хурсэн түвшингээ ахиулах, саяын ярьж байгаа зарчмын асуудлуудыг явуулахын тулд идэвхитэй оролцоотой байх нь чухал. Бид ярьсан зүйлүүдээ ажил болгох тал дээр өөрсдийн оролцоо, хэрэгжилтэнд оролцох, хамтран ажиллах тал дээр анхаараарай гэдгийг Зөвлөлийн гишүүддээ хүсэлт болгож хэлье.

Б.Долгор: Ерөнхий сайд Танд баярлалаа. Ингээд хурлаа бид үргэлжлүүлзэ. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд 2 асуудал байна. Дотоод журам байгаа. Үүн дээр санал байна уу.

П.Эрдэнэжаргал: Манай Үндэсний зөвлөлийн Ажлын алба дээр ЕСБХБ-ны санхүүжилттэй төсөл хэрэгжиж байгаа. Энэ талаар Цолмон даргаа мэдээлэл өгөх шаардлага бий юу?

Б.Долгор: Товч мэдээлэл өгье. Өөр санал байхгүй бол хэлэлцэх асуудлын нэгдүгээр асуудал болох 2010 оны тайлангын танилцуулгаа хийе.

I.ХЭЛЭЛЦСЭН нь: “Харт Нойрс” лтд болон “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн консервиумаас гаргасан Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2010 оны аудитын нэгтгэсэн тайлан

Тайлангийн талаар Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн ахлах аудитор Н.Эрдэнэцог танилцуулав. (Танилцуулгыг хавсаргав)

Б.Долгор: Энэ тайлантай холбогдуулаад Сангийн яамныхаа санал дүгнэлтийг сонсоё.

С.Мягмардаш: Монгол Улсын ОҮИТБС-ын 5 дугаар тайланг баталгаажуулсан дүнг өнөөдөр хэлэлцэж байна. Тавдугаар тайланд Сангийн яамнаас нийдээ 478 аж ахуйн нэгжээр тайланг нэгтгэж гаргасан байгаа. Үүнээс 50 сая төгрөгөөс дээш хэмжээний татвар, хураамж төлсөн 150 компанийг сонгож авч баталгаажуулалтын ажлыг хийсэн байгаа. Компанийг сонгох ажилд Сангийн яам оролцоогүй гэдгээ энэ дашрамд дурдая.

Зөрүүгийн хувьд тайлангийн цэвэр зөрүү 356,700 төгрөг гэсэн дүнтэй байна. Энэ нь өнгөрсөн оны зөрүүнээс ихээхэн хэмжээгээр буурсан. Эндээс харахад компаниуд, төр засгийн байгууллагуудын хувьд тайлагнах ажил жилээс жилд сайжирч байна гэж дүгнэж болохоор байна. Нөгөө талаар шийдвэрлэгдээгүй зөрүү 12 компани дээр гарсан байна. Энэ нь 150 компаний дотор авч үзэхийн бол хувийн жингийн хувьд ихээхэн бага тоо юм.

Төсвийн шинэ хууль УИХ-аар батлагдсан. Хууль бол бүрэн хэмжээгээр 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжих ёстой. Төсвийн тухай хуулиар төрийн захиргааны байгууллага хандив, тусlamж авах явдал хязгаарлагдсан байгаа. Зөвхөн

сургууль, эмнэлэг, соёлын байгууллага тодорхой хэмжээнд хандив авч болно гэсэн ийм зөвшөөрөгдсөн хэмжээтэй. Харин төрийн захиргааны байгууллагууд 2013 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлээд цаашид нэг ч төгрөгийн хандив тусlamж авахгүй болж байгаа.

Олборлох үйлдвэрлэлийн тайланг чанаржуулах, гаргаж байгаа хүмүүсийн мэдлэг боловсролыг сайжруулах чиглэлээр ажлын албаны зүгээс холбогдох төрийн захиргааны байгууллагууд, ялангуяа сургалтын чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах нь зүйтэй гэсэн саналыг зөвлөлийн хурал дээр оруулж байна. Ялангуяа орон нутгийн сумдын хэмжээнд энэ ажлыг зохион байгуулах шаардлагатай байгааг зориуд дурдах ёстой. Ингэснээр тайлангийн хугацаа богиносох, чанар сайжрах, нэгтгэлийн ажилд тавих хяналт илүү сайжрах бололцоотой юм. Анхдагч тайланг аудитын байгууллагаар баталгаажуулж хүлээж авах гэдэг асуудал бол өмнөх жилүүдэд дурдагдаж байсан. Гэхдээ энэ бүрэн хэрэгжихгүй байна. Цаашид энэ дээр анхаарах ёстой. Тайланд тодорхой нэр зааж орж ирсэн хандив тусlamж өгсөн гэж тухайн аж ахуйн нэгж, компанийн анхан шатны баримтаар батлагдаад байгаа хэрнээ төрийн захиргааны байгууллагууд аваагүй гэсэн тайлбар ирүүлсэн энэ асуудал дээр хууль хяналтын байгууллагын шугамаар зориуд шалгалт хийж, энэ асуудлыг цэгцлэх арга хэмжээг авах шаардлагатай.

Б.Долгор: Танилцуулгаас асуух хүн байна уу?

П.Эрдэнэжаргал: Түрүүчийн дээр дурдсан орон нутаг дээр өгсөн хандив дэмжлэг дээр гарсан зөрүүг дахин хэлэх гээд байна. Цогцэций сум дээр үндэсний тайланд сум нь 10 саяыг авсан гээд, Энержи ресурс 10 саяыг өгсөн гээд тайлан гарсан байдаг. Гэтэл сумын түвшинд хийсэн хавсралт тайлангаар 2-уулаа 418-ыг нэг нь өгсөн нөгөө нь авсан гээд 400 сая гаран төгрөгийн зөрүү гараад байна. Үүн дээр хэлэх тайлбар хийх зүйл байна уу

Д.Мэндбаяр: Энэ дээр нэгтгэлийн зөрүү гарсан юм шиг байна. Энержи ресурсын нэгдсэн тайлан дээр 500 хэдэн сая төгрөгийн хандив дэмжлэг байгаа. Сумын түвшин дээрээ 418 сая гэж байсан. Тэр хоёрын хооронд нэгтгэгдэх дүн нь хувийн сургууль, газруудад өгсөн сургалтын төлбөр энэ тэрийг Үндэсний тайлан дээр хасч нэгтгэдэг юм. Хувийн сургуульд өгсөн хандив Үндэсний нэгтгэлд хасагдаж нэгтгэгдсэн. Гэхдээ яг энэ нэгдсэн бүх аймгийн сумдад өгсөн хандив энэ нэгтгэл дээр жаахан зөрүү гарсан байна. Энэ дээр нэгтгэлийн алдаа болсон байна. Нэгдсэн тайлан дээр дүн нь хассан дүнгээрээ таарч байна.

Б.Долгор: Өөр асуулт байна уу. За асуулт байхгүй байна. Саналтай хүн байна уу?

Н.Дорждарь: Тайлан маань ийм зузаан болсон байна. Таван тайлан гаргасан. 6 дахь нь гарах гэж байна. Тайланг электрон хэлбэрээр датабааз хэлбэрт оруулаад ашиглах бололцоо байна. Дэлхийн банкнаас Төлсөн Авснаа Нийтэл эвсэлд тэтгэлэг өгсөн байгаа. Тэрэнд энэ 5-н жилийн өгөгдлийг электрон хэлбэрээр нэгтгэх асуудлыг дэмжих бололцоо байна. Үүн дээр Ажлын алба ТАН эвсэлтэй хамтраад энэ ажлыг оруулчихвал зүгээр юм бол уу. Тэгээд бас өнөөдрийн хуралдааны тэмдэглэлд энэ санааг оруулвал зүгээр болов уу

Д.Зоригт: Өнгөрсөн жилийн тайланг хурлаар хэлэлцэхэд би саналаа хэлж байсан. Бид нар энд суугаад тайлангаа хэлэлцдэг нь нэг сайн. Гэхдээ бид энэ олон компанийн асуудлыг хэлэлцээд байгаа нь үр дүн багатай байна. Энэ хэлэлцүүлэг хаана, аль шатанд явагдах ёстой вэ гэвэл эхний ээлжинд аймаг, сумууд дээр явмаар байгаа юм. Энэ ажлыг зохион байгуулаач гэхэд хөрөнгө мөнгө нь хүрэхгүй байна уу, зохион байгуулалтад нь болохгүй байна уу гэдгийг хэлмээр байна бидэнд. Шаардлагатай бол хуваагаад Засгийн газрын байгууллагуудыг оролцуулаад тайланг нь тэр сумд руу явуулаад тэнд буй ТББ-уудыг оролцуулаад сумын Засаг дарга зэргийг нь байлгаж байгаад хэлэлцүүлмээр байна. Ингэж хэвшүүлэхгүй бол 3, 4, 5 дахь удаагаа энэ өрөөнд хэдэн сайд, дарга нар хоорондоо хэлэлцээд өнгөрдөг нь ямар ч байдлаар хангалтгүй байна. Эцсийн үр дүндээ хүрэх ёстой газар нь аймаг, сумын иргэд юм. Сум, аймгийн түвшинд хэлэлцүүлэх ажлыг манай энэ төслийнхөнд үүргийг нь өгөөд Зөвлөлөөс нэг нэг хүн очоод томоохон сумууд дээр хэлэлцүүлэг зохион байгуулья. Гол гол газруудад хэд хэдэн хэлэлцүүлэг хийе. Одоо хэлэлцүүлгийг шинэ шатанд гаръя. Одоо яах ёстой вэ гэдэгт та бүхэн саналаа хэлээч. Шаардлагатай бол аймаг, сумдуудад үүрэг өгдөг шүү дээ. Энэний дагуу Засгийн газрын танилцуулга хийгээд сум сумаар нь, аймаг аймгаар нь салгаж аваад энийг явж ийм ийм хүмүүс хэлэлцүүл гэдэг тийм тогтоол гаргаад явуулдаг ч юм уу.

Ш.Цолモン: 2012 оны төлөвлөгөөнд Өмнөговьд гэх мэт орон нутагт ажиллахаар байгаа. Энэ ажил одоо 5 дугаар сараас эхлэх гэж байна.

Д.Зоригт: Бус бусээр нь биш, сум сумаар нь хэлэлцүүлэг хиймээр байна. Өмнөговийн Цогцэций, Ханбогд, Гурвантэс, Сэлэнгийн Ерөө, Мандал гээд 10 сум сонгож аваад хиймээр байна.

Б.Долгор: Зөвлөлийнхөө гишүүдэд үүрэг өгөөд графикийг нь гаргаад Ажлын алба зохион байгуулая. Хамгийн гол нь мөнгөний асуудлыг яаж шийдэх вэ гэдэг асуудал байна.

Д.Зоригт: Энэ асуудал дээр яамдуудад үүрэг өгөхөд яамдууд нэг нэг хүнээ даагаад явчих боломжтой.

Б.Долгор: Тэгэе. Төлөвлөгөөний дагуу ийм байдлаар зохион байгуулая.

Л.Нямсамбуу: Энэ санаачлагын ажил хэдэн жил дараалаад явахад эцэстээ хандлага, үр дүн нь ямар байна вэ гэдгийг энд ярих ёстой. Урд урд жилүүдийнхээс гайгүй болох төлөвтэй юм. Гайгүй үр дүнд хүрэх янзтай байна. Юугаар нотлогдож байна вэ гэвэл зөрчил их багассан байна, тайлангуудын зөрүүнээс гарах мөнгөний тоо багассан байна, тайлан гаргах, хүлээж авахтай холбоотой байгууллагуудын хоорондын уялдаа ноднингийнхтой харьцуулахад гайгүй болсон байна. Хамрагдах хүрээ жил бүр нэмэгдээд байна. Нийгэмд гарч байгаа уур амьсгал, энэний нөлөөллийг тусгаж авч байгаа байдал, энэ өөрөө хүмүүст юмуу, аж ахуйн нэгжүүдэд яаж нөлөөлж байна гэдэг талаас нь үзэх юм бол тодорхой хэмжээгээр үр дүн гарч байгаа. ТББ-ын зүгээс аймаг сумын түвшинд хэлэлцүүлэг хийхийг дэмжиж байна, идэвхитэй оролцено.

П.Эрдэнэжаргал: 5 дахь тайлан гарчихлаа. Зоригт сайд хэллээ орон нутагт уул уурхайн үйл ажиллагаа маш эрчимтэй явж байна гэж, орон нутагт хэлэлцүүлгээ зохион байгуулья гэж. Үндэсний хэмжээний нэг чуулга, хурал хиймээр байна. Монголын эдийн засгийн форумын нэг хуралдаан болгодог ч юм уу, 5 тайлан гарна гэдэг бас л нэлээн их

ажил. Ямар нэгэн байдлаар үүнийг тэмдэглээд компаниудаа урамшуулаад сэтгэл санааны ч юмуу тийм урамшуулал үзүүлбэл ясийм бэ.

Б.Долгор:Өнөөдрийн хуралдаанаар аудитынхаа нэгтгэсэн тайланг албан ёсоор баталж байгаа ийм ач холбогдолтой хурал. Дараах шийдвэрийг гаргаж байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1.Харт Нойрс лтд болон Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн консерциумын гаргасан “Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2010 оны аудитын нэгтгэсэн тайлан”-г дэмжиж хуралдаан дээр гишүүдийн гаргасан саналыг тусган батлахаар тогтов.

2.Тайлангаар Засгийн газрын байгууллагуудтай холбогдон гарсан 11 сая төгрөгийн зөрүүг Үндэсний зөвлөлийн гишүүд, ажлын албаны ажилтнууд мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран шалгахаар тогтов.

3.Энэхүү дэлгэрэнгүй тайлан болон хураангуй тайланг Монгол Улсын ОҮИТБС-ын ажлын албаны вебсайт болон Үндэсний зөвлөлийн гишүүнээр 3 талыг төлөөлөн оролцогч талуудын вебсайтад тус тус тавьж нийтэд ил тод болгохоор тогтох, гишүүдэд е-майлаар хүргүүлж, сурталчилгаанд хяналт тавихыг Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонд даалгав.

4. “Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2010 оны аудитын нэгтгэсэн тайлан”-г ОҮИТБС-ын олон улсын Удирдах хороонд илгээхийг Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмонд даалгав.

5.Тайланг олон талт оролцогчдын уулзалтаар хэлэлцүүлэхийг Үндэсний зөвлөлийн 3 талын төлөөлөл Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Д.Дамба, Нээлттэй нийгэм форумын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал нарт үүрэг болгож, хэлэлцүүлэг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонд даалгав.

6. “Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2010 оны аудитын нэгтгэсэн тайлан”-г ОҮИТБС-ын Ажлын албатай хамтран нийтэд мэдээлж сурталчлахыг Засгийн газрын хэвлэл мэдээллийн албанд даалгав.

7.Гишүүдийн Үндэсний зөвлөлийн хуралдаан дээр гаргасан санал, Ажлын албаны 2011 оны үйл ажиллагаанд тусгагдсаны дагуу тайланг аймаг, сумаар хураангуйлан гаргаж тус тусын аймаг, сумдад хүргүүлэх, хэлэлцүүлэг зохион байгуулахаар тогтох, хэлэлцүүлэг явуулах аймаг, сум, уг хэлэлцүүлгийг зохион байгуулах Үндэсний зөвлөлийн гишүүдийн хуваарийг ажлын шугамаар батлан хэрэгжүүлэхээр тогтов.

8.ОҮИТБС-ыг Монгол Улсад хэрэгжүүлсэн дүн, 5 удаагийн тайлангийн талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулж, улмаар Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо болон Төсвийн байнгын хороонд хүргүүлж танилцуулахаар тогтов.

9.Дэлгэрэнгүй болон төрөлжсөн хураангуй тайланг ОҮИТБС-ыг сурталчилсан сурталчилгаа, үзүүлэн таниулах материал зэргийн хамт хэвлэмэл материал, CD-д

бичих зэргээр сурталчилгааны материал бэлтгэн Үндэсний зөвлөлийн гишүүдэд өгөх, орон нутагт хүргүүлэх зэргээр сурталчлахыг Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонд даалгав.

10. ОУИТБС-ын Үндэсний хэмжээний чуулган зохион байгуулахаар тогтох, хугацаа, хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэхийг Үндэсний зөвлөлийн З талын төлөөлөл Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Д.Дамба, Нээлттэй нийгэм форумын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал нарт даалгав.

11. Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдын ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн хуралдаанд дээр өгсөн үүргийн дагуу дараахь бодлого боловсруулж, тодорхой арга хэмжээ авах саналаа Үндэсний зөвлөл болон Засгийн газарт оруулахаар тогтов:

11.1. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх нэрийн дор арилжиж байгаа хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, аливаа тусгай зөвшөөрөлтэй холбоотой авилга, хээл хахуулийн асуудлыг арилгах, тусгай зөвшөөрлийг хөрөнгө, санхүү, технологийн өндөр чадвартай компанийд олгож байх, эдгээр шаардлагад нийцүүлэн Ашигт малтмалын газарт бүтцийн өөрчлөлт хийж, мэдлэг, ур чадвар бүхий ажилтнуудаар аппаратыг бүрдүүлэх арга хэмжээ авахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Ашигт малтмалын газрын дарга Алтансүх нарт даалгав;

11.2. Байгаль хамгаалах, экологийн бодлогыг тэргүүн ээлжинд тавьж, орон нутгийн тусгай хэрэгцээнд байгаа болон ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий газраас бусад газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, зөвхөн Улсын Их Хурлын зөвшөөрлөөр тусгай хэрэгцээнээс гаргадаг байх, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх арга хэмжээ авч Засгийн газрын хуралдаанд оруулахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Цогтбаатар, Ашигт малтмалын газрын дарга Алтансүх нарт тус тус даалгав;

11.3. Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордын тоог нэмэгдүүлэх шаардлагыг харгалзан өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашид баримтлах бодлогыг тодорхойлж, стратегийн ордын нэмэлт жагсаалтыг Засгийн газраар хэлэлцүүлэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлэхийг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Сангийн сайд Д.Хаянхярваа, Ашигт малтмалын газрын дарга Алтансүх нарт тус тус даалгав.

II. ХЭЛЭЛЦСЭН нь: Засгийн газар болон компаниудын ОУИТБС-ын 2011 оны тайлан гаргах ажлын явцын тухай

Б.Долгор: Тайлан гаргах ажил харьцангуй сайн явж байна. 2011 оны тайланг 276 компани гаргаж Ажлын алба, Ашигт малтмалын газар, Газрын тосны газар, Цөмийн энергийн газарт ирүүлсэн байна. Үүнээс олборлолт хийж буй нь 154, хайгуул хийж байгаа нь 110, газрын тосны 12 компани байна. Засгийн газрын хүлээн авсан татвар, төлбөрийн тайланг Үндэсний татварын ерөнхий газар гаргаж байгаа, Сангийн яам эцэслэн хянаж 5 дугаар сард багтаан гаргаж дуусгана. Монгол Улсын нэгтсэн тайландаа 200 компанийг хамруулна гэсэн төлөвтэй байгаа. Аудиторын консервиумын сонгон

шалгаруулалт энэ долоо хоногт дуусах юм. Одоогийн байдлаар компаниудаас ирүүлсэн техникийн саналын үнэлгээгээр "Харт Нойрс" лтд болон "Улаанбаатар аудит корпораци" ХХК-ийн консерциум болон Монгол-Малайзын консерциум шалгараад байна. Санхүүгийн саналын үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан консерциумтай 5 дугаар сард гэрээ байгуулна. Ажлаа 6 дугаар сарын 1-нээс 9 дүгээр сарын 1 гэхэд дуусгахаар явж байгаа. Тайлангаа гаргасан 276 компаний нэrsийг жагсааж та нарт өгсөн байгаа. Жагсаалтад ороогүй өөрөөр хэлбэл тайлангаа гаргаагүй компаниудад хариуцлага тооцох энэ ажлыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт уламжилж тодорхой арга хэмжээг авахуулах саналтай байна. Тайлан гаргах үүрэгтэй Засгийн газрын байгууллагууд бүгдээрээ тайлан гаргасан мэдээлэл байгаа. Эндээс асуух зүйл байна уу.

Ш.Цолмон: Компаний тоог 5 дугаар сарын 1-нээр тасалбар болгож Б.Долгор даргад өгсөн. Үүний дараа 2 компанийн тайлан нэмж ирсэн. Энэ хоёр бол Шанлун, Хар тарвагатай гэсэн компаниуд юм. Бид энийг жагсаалтад оруулж амжаагүй. Иймд жагсаалтыг 276 биш 278 болгох хүсэлтийг Үндэсний зөвлөлд тавьж байна. Эдгээр компаниуд хөдөө ид ажил нь явагдаад хоцорсон тал байгаа.

Б.Долгор: Асуулт байна уу, Саналтай хүн байна уу.

Н.Дорждарь: Би аудитын консерциум сонгон шалгаруулах үнэлгээний хороонд орсон байгаа. Тэгэхлээр аудитын консерциумыг сонгон шалгаруулах үзүүлэлтүүдийг эргэж харах ажлын хэсэг байгуулах шаардлага байна. Тэгэхгүй бол туршлага гэдэг заалт нь их өндөр оноо авдаг. Манай тайлан 5 удаа гарахад сүүлийн гурван жилийн тайланг нэг консерциум гаргасан. Сүүлийн дөрвөн тайлан гаргасан 2 компани бол техникийн саналаар тэргүүлж яваа юм. Тэгэхлээр энэ дээр бодолцох зүйл байна. Яагаад гэвэл нэг компани олон жил хийгээд байхлаар шинэ соргог юм гарч ирэхгүй, чанарын асуудалд нөлөөлөх болов уу гэсэн асуудал байгаа юм.

Б.Долгор: Энэ саналыг дэмжиж байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Тайлан гаргаагүй компаниудын тухай судалгааг 2011 оны 6 дугаар сарын 1-нээр тасалбар болгон гаргаж, нэrsийг төвийн өдөр тутмын хэвлэлд гаргах, улмаар холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулахаар Ашигт малтмалын газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлэхийг Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонд даалгав.

2. Засгийн газрын 2011 оны ОҮИТБС-ын нэгдсэн тайланд мэдээгээ ирүүлээгүй төрийн захиргааны зарим байгууллагуудын удирдлагад үр дүнгийн гэрээний дагуу сануулга өгөх, хариуцлага тооцож арга хэмжээ авахыг Эрдэс баялаг, эрчим хүчиний сайд, Үндэсний зөвлөлийн орлогч дарга Д.Зоригт, Сангийн сайд, Үндэсний зөвлөлийн гишүүн Д.Хаянхярваа нарт даалгав.

3. Монгол Улсын ОҮИТБС-ын 2011 оны аудитын тайлан гаргах аудитын компанийн консерциумыг сонгон шалгаруулах тендерийг 2012 оны 5 дугаар сард багтаан зохион байгуулж дуусган гэрээ байгуулахыг Сангийн сайд, Үндэсний зөвлөлийн гишүүн Д.Хаянхярваа, Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Долгор, Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмон нарт даалгав.

4. Хуралдаан дээр гарсан саналын дагуу аудитын консерциумыг сонгон шалгаруулах үзүүлэлтүүдийг хянан боловсруулах ажлын хэсэг байгуулах шаардлагатай.

Хуралдааны тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх, ОУИТБС-ын Үндэсний
Зөвлөлийн нарийн бичгийн дарга

Б.Долгор

Тэмдэглэлийг хөтөлсөн:

Ажлын албаны харилцааны мэргэжилтэн

С.Батбаяр